Mongolian Re

ҮНДЭСНИЙ ДАВХАР ДААТГАЛ ХК

# ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 оны 01 сарын 27 өдөр | Дугаар: А/09 | Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, Сангийн сайдын 2017 оны 01 дүгээр тушаалаар батлагдсан Үндэсний давхар даатгал ХК-ийн дүрмийн 4.3.2, Гүйцэтгэх захирлын 2022 оны А/01 дүгээр тушаалаар батлагдсан “Хөдөлмөрийн дотоод (журам) хэм хэмжээ”-ний 2.8.4, 2.11, 6.1.1, 6.1.7.2-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үндэсний давхар даатгал ХК-ийн 2023 онд хийж гүйцэтгэх “Ажлын төлөвлөгөө”-г хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан төлөвлөгөөний биелэлтийг ханган ажиллаж, гүйцэтгэлийг 2024 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор үе шаттай гарган танилцуулахыг газрын дарга нарт үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаалыг газрын дарга нарт танилцуулахыг хүний нөөцийн ажилтан Т.Уянгад даалгасугай

ҮНДЭСНИЙ ДАВХАР ДААТГАЛ ХК Mongolian Re УЛААНБААТАР ХОТ

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.ЖАВХЛАНТ

:\Users\Username\Desktop\Тушаал.docx

Боловсруулсан: Т. Ценга
Хянасан:
Хувь: 2
Огноо: 2023.02.27.

ҮНДЭСНИЙ ДАВХАР ДААТГАЛ ХК
Mongolian Re
УЛААНБААТАР ХОТ
1119282186 ☎ 5885612

*Үндэсний давхар даатгал ХК-ийн Гүйцэтгэх захирлын 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/09 дүгээр тушаалын ХАВСРАЛТ*

# ҮНДЭСНИЙ ДАВХАР ДААТГАЛ ХК-ИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| д/д | | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хийж хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Хүрэх үр дүн | Хугацаа | Хариуцах нэгж |
|---|---|---|---|---|---|---|
| 0 | | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| **1. Давхар даатгалын үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хүрээнд:** | | | | | | |
| 1. | 1. | Компанийн давхар даатгалын үйл ажиллагааг зохион байгуулж, хөдөө аж ахуйн болон бусад даатгалын бүтээгдэхүүнийг давхар даатгах эрсдэлийн судалгаа, андеррайтинг хийж, үнийн санал боловсруулах, бүртгэх; | МИД-д оролцогч даатгалын компаниудын 2023 оны борлуулалтын төлөвлөгөөг нэгтгэх | o МИД-ын 2023 оны борлуулалтын төлөвлөгөө нэгтгэгдсэн байна. | 1 сар | Андеррайтинг, бизнес хөгжлийн газар Андеррайтингийн алба |
| | | | МИД-ын давхар даатгалын хураамжийн тооцооллыг хийх, урьдчилгаа төвлөрүүлэх | o Шаардлагатай тооцооллууд бүгд цаг хугацаандаа хийгдсэн байна. Даатгалын компаниудаас давхар даатгалын хураамжийн урьдчилгааг бүрдүүлж авсан байна. | 1 сар | |
| | | | Эрчимжүүлсэн мал аж ахуйн даатгалын андеррайтинг хийж, үнийн санал боловсруулах, бүртгэх | o Даатгалын бүтээгдэхүүн тус бүрийн андеррайтинг хийж, үнийн саналыг давхар даатгуулагчид танилцуулж, программд бүртгэсэн байна. | 1-12 сар | |
| | | | Бусад даатгалын бүтээгдэхүүнийг /гэнэтийн осол, эмчилгээний; хөрөнгийн; авто тээврийн хэрэгслийн; ачаа тээврийн; барилга угсралтын; агаарын хөлөг, агаарын хөлгийн хариуцлагын; хариуцлагын; санхүү, итгэлцлийн; зээлийн; дотоодын трити/багцын/ судлах, асуулгын маягт боловсруулах, авах, андеррайтинг хийх, үнийн санал боловсруулах, бүртгэх | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2. | 2. | Давхар даатгалын гэрээ болон баталгааг даатгалын компаниудтай байгуулах, бүртгэх, даатгалын компаниуд, зуучлагч банкнууд болон бусад оролцогч талуудтай хамтарч ажиллах; | МИД-д оролцогч даатгалын компаниудтай давхар даатгалын гэрээ байгуулах, банкнуудтай зуучлалын гэрээ байгуулах | ○ МИД-ын борлуулалт үр дүнтэй зохион байгуулагдаж, МИД-д оролцогч даатгалын компаниудтай давхар даатгалын гэрээ, банкуудтай зуучлалын гэрээ байгуулагдсан байна. | 1-2 сар | Андеррайтинг, бизнес хөгжлийн газар Андеррайтингийн алба |
| | | | МИД-ын борлуулалтад оролцогч даатгалын компаниуд болон зуучлагч байгууллагуудтай хамтран ажиллаж борлуулалтад хяналт тавих, мэдээллээр хангах | ○ Тухайн жилийн МИД-ын борлуулалтын үйл ажиллагаа амжилттай хэрэгжиж, борлуулалтын бүртгэл үнэн зөв хийгдэж, Хамтын эрсдэлийн сангийн хөрөнгийг удирдан зохион байгуулсан байна. | 1-8 сар | |
| | | | Хамтын эрсдэлийн санг бүрдүүлэх, зохион байгуулах | | 9-11 сар | |
| | | | МИД-ын давхар даатгалын хураамжийг төвлөрүүлэх | ○ Давхар даатгалын хураамж /1.63 тэрбум төгрөг/ гэрээнд заасан төлбөр төлөх хуваарийн дагуу бүрэн төвлөрч, нөөц сан бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлсэн байна. | 9-11 сар | |
| | | | МИД-д оролцогч талуудад сургалт зохион байгуулах, оролцогч талууд хамтарч ажиллах | ○ МИД-ын талаар сургалт зохион байгуулагдаж, мэдээлэл хангалттай хүргэгдсэн байна. | 1-12 сар | |
| | | | Бусад даатгалын бүтээгдэхүүний /эрчимжүүлсэн мал аж ахуйн, гэнэтийн осол, эмчилгээний; хөрөнгийн; ачаа тээврийн; авто тээврийн хэрэгслийн, барилга угсралтын; агаарын хөлөг, агаарын хөлгийн хариуцлагын; хариуцлагын; санхүү, итгэлцлийн; зээлийн; дотоодын трити/багцын/ давхар даатгалын гэрээ/баталгаа байгуулах, бүртгэх | ○ Давхар даатгалын хураамжийн төлөвлөгөө биелж /хагас жил-2.99 тэрбум төгрөг, бүтэн жил 5.0 тэрбум төгрөг/, баталгаа/гэрээ хийгдсэн байна. | 1-12 сар | |
| 3. | 3. | Олон улсын давхар даатгалын үйл ажиллагааг зохион байгуулж, олон | Олон улсын давхар даатгагчаас үнийн санал авах | ○ Холбогдох даатгалын бүтээгдэхүүнүүд дээр олон улсын давхар даатгагчаас үнийн санал авч, компанийн санхүүгийн нөөцөөс давсан эрсдэлийг олон улсын давхар даатгалд шилжүүлэх гэрээг байгуулсан байна. | 1-12 сар | |
| | | | Олон улсын давхар даатгалын компанид эрсдэлээ шилжүүлэх, давхар даатгалын гэрээ байгуулах | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | улсын давхар даатгалын гэрээ болон баталгааг байгуулах, бүртгэх; | Олон улсын давхар даатгагчид давхар даатгалын хураамж шилжүүлэх | ○ Олон улсын давхар даатгагчидтай хамтын ажиллагааг өргөжүүлж, дахин давхар даатгалын гэрээ хийгдэж, давхар даатгалын хураамж бүрэн шилжсэн байна.<br>○ Хамтын ажиллагаа өргөжсөн байна. | 1-12 сар | |
| | | | Олон улсын давхар даатгалын байгууллагуудтай хамтран ажиллах, өөрсдийн чадавхыг сайжруулах | | | |
| 4. | 4. | Давхар даатгалын үйл ажиллагааны журам болон бусад журмыг мөрдлөг болгон ажиллах; | Холбогдох хууль, журмын төсөл, ажлын хэсгүүдэд саналаа өгч ажиллах | ○ Тариалангийн даатгалын тухай хууль, Гамшгийн даатгалын тухай хуулийн төсөл, Даатгагчийн баталгааны холбогдох журмын төсөл болон бусад ажлын хэсгүүдэд саналаа өгч ажилласан байна. | 1-12 сар | Андеррайтинг, бизнес хөгжлийн газар Андеррайтингийн алба |
| 5. | 5. | МИД болон давхар даатгалын бүтээгдэхүүний программ хангамжийг хөгжүүлэх, хэрэгжилтийг хангаж ажиллах; | МИД болон давхар даатгалын программын сайжруулалт, өөрчлөлт хийх | ○ 2023 онд ашиглах МИД болон давхар даатгалын программ хангамжийг хөгжүүлсэн байна. | | |
| | | | Давхар даатгалын программ хангамжийг боловсруулахад шаардагдах ажлыг хийх | ○ Давхар даатгалын программ хангамжтай холбоотой мэдээллийн системийн хэрэгжилт хангагдсан байна. | | |
| | | | Өгөгдлийн санг зохион байгуулах, шаардлагатай өөрчлөлт, нэмэлт мэдээллийг оруулах, суурь мэдээллүүдийг жил бүр шинэчлэх | ○ 2023 оны өгөгдлийн санг зохион байгуулж, мэдээлэл шинэчлэгдсэн байна. | | |
| | | | МИД-ын программ хангамжаас болон баталгаанаас илэрсэн алдаа, зөрчлийг засаж залруулах, зөвлөгөө өгөх | ○ МИД борлуулалтын үе болон хаалтын үйл ажиллагааны үед программын болон баталгаанаас гарсан алдаа зөрчлийг цаг тухай бүрд нь засаж залруулсан байна. | | |
| | | | SSL, Firewall, Server, Database болон бусад тохиргоонуудыг хийх | ○ Бусад ажил /SSL, Firewall, Server, Database болон бусад тохиргоонууд/ хийгдсэн байна. | | |
| **2.Зах зээлийн судалгаа хийж, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ гаргаж турших ажлын хүрээнд:** | | | | | | |
| 6. | 1. | Шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх, борлуулалтын | Зах зээлийн болон эрсдэлийн судалгаа хийж, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ гаргаж турших ажлыг хэрэгжүүлэх | ○ Макро эдийн засгийн орчны судалгаа, зорилтот салбарын зах зээлийн судалгаа болон холбогдох судалгаа шинжилгээ хийгдсэн байна. | 1-12 сар | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | сувгийг нэмэгдүүлэх, судалгаа шинжилгээ хийх; | Даатгагчийн баталгааны давхар даатгалын бүтээгдэхүүн боловсруулах, давхар даатгалын санг байгуулах, хураамж төвлөрүүлэх, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх | o Даатгагчийн баталгааны давхар даатгалын бүтээгдэхүүний загварыг боловсруулсан байна.<br>o Шинэ бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэх, борлуулалтын сувгийг нэмэгдүүлэх чиглэлээр үр дүнтэй ажилласан байна. | 1-12 сар | Андеррайтинг, бизнес хөгжлийн газар<br>Бизнес хөгжил, төслийн алба |
| | | | Уул уурхай, агаарын хөлгийн даатгалын шинэ бүтээгдэхүүний судалгаа шинжилгээ хийх, загвар гаргах | o Шинэ бүтээгдэхүүний загварыг боловсруулсан байна. | | |
| | | | Туршигдсан бүтээгдэхүүний зах зээлийг тэлэх, бүтээгдэхүүн үйлчилгээг сайжруулах | o Хэрэгжиж буй бүтээгдэхүүний зах зээлийг тэлэх сайжруулах, борлуулалтын сувгийг нэмэгдүүлэх чиглэлээр үр дүнтэй ажилласан байна. | | |
| | | | Бүтээгдэхүүн үйлчилгээтэй холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулах, судлах | o Давхар даатгалын шинэ бүтээгдэхүүн зах зээлд нэвтрэхтэй холбогдуулан хууль, журмын төсөлд санал зөвлөмж өгч, журам, гэрээ болон бусад холбогдох баримт бичиг боловсруулагдан баталгаажсан байна.<br>o Гадаадын улс орнуудын хууль, эрх зүйн зохицуулалтыг судалсан байна. | | |
| | | | Гамшгийн эрсдэлийн даатгалын эрхзүйн орчныг бүрдүүлэх, судалгаа шинжилгээний байгууллагуудтай хамтран ажиллах | o Гамшгийн эрсдэлийн даатгалын бүтээгдэхүүний эрхзүйн зүйн орчныг бүрдүүлэхтэй холбогдуулан хууль, журмын төсөлд санал зөвлөмж өгч, судалгаа шинжилгээний байгууллагуудтай хамтран ажиллаж, журам, гэрээ болон бусад холбогдох баримт бичиг боловсруулагдан баталгаажсан байна. | | |
| 7. | 2. | Олон улсын болон дотоодын төр, хувийн хэвшлийн түншлэлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх; | Дотоодын болон гадаадын байгууллагуудтай харилцаа холбоо тогтоож, хамтран ажиллах талаарх нөөц боломжийг судлах | o Компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор төрийн болон хувийн хэвшлийн томоохон ААН-үүдтэй уулзалтуудыг амжилттай зохион байгуулж, давхар даатгалын бизнесийн санал тавьж ажиллан үр дүнд хүрсэн байна. | 1-12 сар | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | Төсөл хэрэгжүүлэхтэй холбоотой ажлыг гүйцэтгэж, үр дүнд хүргэх | o Уул уурхайн бус экспортлогчдын судалгаа, худалдан авагчдын зээлийн хязгаарын судалгаа болон холбогдох бусад судалгааг боловсруулж, холбогдох уулзалтуудыг хийж, экспортлогчдыг даатгалд хамруулсан байна. | 1-12 сар | |
| | | | Экспортын даатгалын бүтээгдэхүүнийг борлуулах, холбогдох хууль эрхзүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр холбогдох төрийн байгууллагууд, хувийн хэвшилтэй хамтарч ажиллах | o Экспортын даатгалын бүтээгдэхүүнийг борлуулах, хууль эрхзүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай уулзалтуудыг амжилттай зохион байгуулж, үр дүнд хүрсэн байна. | | |
| | | | Компанийн үйл ажиллагаанд олон улсын санхүүгийн чадавх болон зээлжих зэрэглэлийн үнэлгээ тогтоолгох | o Холбогдох журмын хүрээнд олон улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээ хийлгэх компанийг сонгон шалгаруулсан байна.<br>o Олон улсын санхүүгийн чадавх болон зээлжих зэрэглэлийн үнэлгээ хийгдсэн байна. | 2-12 сар | Захиргаа, удирдлагын газар<br>Андеррайтинг, бизнес хөгжлийн газар |
| 8. | 3. | Компанийн бизнесийн стратеги, төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах; | Компанийн бизнес төлөвлөгөө, стратеги төлөвлөгөөг боловсруулах | o Компанийн бизнес төлөвлөгөө /төлөвлөгөө-1/, стратеги төлөвлөгөөг /төлөвлөгөө-1/ боловсруулан батлуулж, хэрэгжүүлэн ажилласан байна. | 10-12 сар | |
| | | | Компанийн бизнес төлөвлөгөө, стратеги төлөвлөгөөний биелэлтийг гаргах | o Компанийн бизнес төлөвлөгөө /биелэлт-1/, стратеги төлөвлөгөөний биелэлтийг /биелэлт-1/ үнэн зөв бүрэн гаргаж, тайлагнасан байна. | 1-3, 7-9 сар | |
| 9. | 4. | Маркетингийг хөгжүүлэх; | Компанийн үндсэн үйл ажиллагаа, бүтээгдэхүүнийг зах зээлд сурталчлан таниулах жилийн төлөвлөгөө хөтөлбөр, боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах | o Бүтээгдэхүүн үйлчилгээний талаар нэвтрүүлэг, танилцуулга, шторк, контент видео, ярилцлага, нийтлэл зэргийг бэлтгэн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр дамжуулан олон нийтэд түгээсэн байна.<br>o Шаардлагатай брошюр, тайлан сэтгүүл, бусад хэвлэх материалын эхийг боловсруулан цаг тухайд нь хэвлүүлсэн байна. | 1-12 сар | Андеррайтинг, бизнес хөгжлийн газар<br>Бизнес хөгжил, төслийн алба |
| | | | Компанийн вэбсайтыг хөгжүүлэх, орчин үеийн сошиал сувгуудыг ашиглаж бизнесийг хөгжүүлэх | o Компанийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл вэбсайтад тогтмол байршиж, сошиал сувгуудаар түгээгдэн, олон нийтэд түгээгдсэн байна. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Сургалт семинар, олон нийтийн үйл ажиллагаа зохион байгуулах | o Сургалт, семинар, уулзалт, арга хэмжээнүүд үр дүнтэй, амжилттай зохион байгуулагдсан байна. | 1-12 сар | |
| **3. Эрсдэлийн менежмент, хөрөнгийн удирдлагын талаар хэрэгжүүлэх ажлын хүрээнд:** | | | | | | |
| 10. | 1. | Компанийн сангийн хөрөнгийг /МИД-ын хамтын эрсдэлийн сангаас бусад/ холбогдох зохицуулалтын хүрээнд удирдан зохион байгуулах, бүрдүүлэх, төлөвлөх, нөөц сангуудын байршлын тайланг гаргах; | Компанийн алдагдлаас хамгаалах сан, дүрмийн сан, бусад нөөц сангуудын хөрөнгийг холбогдох дүрэм журмын дагуу хөрөнгө оруулалт хийх ажлыг зохион байгуулах, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг биелүүлэх | o Мөнгөн хөрөнгийг холбогдох дүрэм журмын дагуу тухай бүр хөрөнгө оруулалт хийх ажлыг зохион байгуулж, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг биелүүлсэн /хагас жил-2.8 тэрбум төгрөг, бүтэн жил-2.87 тэрбум.төгрөг/ байна. | 1-12 сар | Эрсдэлийн менежмент, хөрөнгийн удирдлагын газар |
| | | | Мөнгөн хадгаламжийн гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, мэдээллийг эмхэтгэн боловсруулах | | | |
| | | | Хөрөнгө оруулалттай холбоотой шаардлагатай тайлан, төлөвлөгөө, шинжилгээ, судалгааг гаргах, холбогдох газарт хүргүүлэх | | | |
| 11. | 2. | Даатгалын үйл ажиллагаанд шаардагдах актуар тооцоолол, тайлан гаргах болон судалгаа хийх; | Шинэ болон хэрэгжүүлж буй даатгалын бүтээгдэхүүний актуар тооцоололд шаардлагатай дата мэдээллийг бэлтгэх, хураамжийн тооцооллыг хийх | o Даатгалын бүтээгдэхүүний хураамж тооцоолол хийгдсэн байна.<br>o Даатгалын бүтээгдэхүүний хохирол үнэлгээний актуар тооцоолол хийгдсэн байна. | | |
| | | | Компанийн актуарын үйл ажиллагаанд шаардлагатай тооцоололтой холбогдох танилцуулгыг цаг хугацаанд нь гаргах | o Шаардлагатай актуар тооцооллын тайланг цаг хугацаанд нь бэлтгэж танилцуулсан байна.<br>o Дата мэдээлэл цуглуулж, эмхэтгэн боловсруулж, статистик анализ хийсэн байна. | | |
| | | | Актуарын тайлан, тооцоололд шаардлагатай судалгаа шинжилгээг хийж гүйцэтгэх | o Мэдээллийг үнэн зөв бүрдүүлж, анхан шатны анализ, дүн шинжилгээг хийсэн байна. | | |
| | | | Актуар тооцооллын арга аргачлалыг хөгжүүлэх, түүнд ашиглагдах загварчлалыг | o Давхар даатгалын гэрээгээр хүлээх эрсдэлийн хэмжээг үнэлэх арга аргачлал, стандартуудыг судалсан /судалгаа-1/ байна. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | боловсруулах, олон улсын стандартыг судлах | | 1-12 сар | Эрсдэлийн менежмент, хөрөнгийн удирдлагын газар |
| | | | Компанийн төлбөрийн чадвар, нөөц сангийн актуар тайланг цаг хугацаанд нь гаргах Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэх | o Компанийн төлбөрийн чадвар /тайлан-8/, нөөц сангийн тайлан /тайлан-4/, хөндлөнгийн актуарын хяналт шалгалтын тайлан /тайлан-1/ үнэн зөв гарч Санхүүгийн зохицуулах хороонд хугацаандаа хүргэгдсэн байна. | | |
| | | | Компанийн үйл ажиллагаанд хийх актуарын үйлчилгээнд хяналт тавьж, зөвлөгөө өгөх, гүйцэтгэлийг хангуулах | o Актуарын шаардлагатай тооцооллыг хангалттай болон найдвартай түвшинд тооцоолсон байна.<br>o Байгууллагын бүх түвшинд мэргэжилтнүүдэд зөвлөгөө өгч, хамтран ажилласан байна. | | |
| 12. | 3. | Олон нийтэд шинээр нэмж үнэт цаас гаргах замаар компанийг нээлттэй хувьцаат компани болгох ажлыг зохион байгуулах | Компанийн энгийн хувьцааны 34 хүртэлх хувьд энгийн хувьцаа нэмж гаргах ажлыг амжилттай зохион байгуулах | o Нэмж гаргасан энгийн хувьцаа зах зээлд амжилттай арилжаалагдаж, компани олон нийтэд нээлттэй хувьцаат компани болсон байна. | 1-3 сар | Ажлын хэсэг |
| 13. | 4. | Чанарын менежментийн тогтолцооны стандарт /ISO: 9001/-ыг нэвтрүүлэх; | Чанарын менежментийн тогтолцооны гарын авлагыг стандартад нийцүүлэн боловсруулж, компанийн үйл ажиллагаанд мөрдүүлсэн байна. | o Чанарын менежментийн тогтолцооны стандартыг нэвтрүүлсэн гэрчилгээ авсан байна. | 1-7 сар | Ажлын хэсэг |
| 14. | 5. | Компанийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх, холбогдох судалгаа боловсруулан тайлагнах; | Байгууллагад учирч болзошгүй даатгалын болон даатгалын бус эрсдэлүүдийг тодорхойлж, эрсдэлийн удирдлагын зохистой арга аргачлалуудыг ашиглан тухайн эрсдэлүүдийг үнэлэх | o Компанийн үйл ажиллагааны эрсдэлийн судалгааг хийж, нийт эрсдэлийн индексийг үнэлэн, тайлан /тайлан-2/ бэлтгэн танилцуулсан байна.<br>o Эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичиг /баримт бичиг-1/ болон Эрсдэлийн удирдлагын журмыг /журам-1/ шинэчлэн ТУЗ-өөр батлуулсан байна. | 1-12 сар | Эрсдэлийн менежмент, хөрөнгийн удирдлагын газар |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Зохицуулагчаас тавьж буй шаардлагыг хангаж ажиллаж байгаа эсэхэд хяналт тавих, холбогдох шинжилгээг хийх, байгууллагын эрсдэлийн үнэлгээний тайланг цаг тухайд нь гаргаж тайлагнах | ○ Санхүүгийн зохицуулах хороонд Эрсдэл болон төлбөрийн чадварын үнэлгээний тайлан /тайлан-1/ хугацаандаа хүргэгдсэн байна. | 1-2 сар | |
| 15. | 6. | Эдийн засаг, бизнесийн орчин болон хөрөнгө оруулалтын сувгийн судалгаа, санхүүгийн тайлангийн шинжилгээ хийх; | Мөнгөн хөрөнгийг зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалтын хэлбэрийн дагуу төлөвлөн зохион байгуулах, оновчтой удирдах, банкнаас бусад хөрөнгө оруулалтын гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, хүүгийн орлогыг тулган баталгаажуулах | ○ Мөнгөн хөрөнгийг зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалтын хэлбэрийн дагуу төлөвлөн зохион байгуулж, оновчтой удирдаж ажилласан байна. | | |
| | | | Хөрөнгө оруулалтын эрсдэлийн ирээдүйн төлөв байдал, эдийн засгийн нөлөөлөл зэрэг хөрөнгө оруулалтад нөлөөлөх тоо мэдээллийг тайлбарлах | ○ Хөрөнгө оруулалтын эрсдэлийн ирээдүйн төлөв байдал, эдийн засгийн нөлөөлөл зэрэг хөрөнгө оруулалтад нөлөөлөх тоо, мэдээллийг /мэдээлэл-4/ боловсруулсан байна. | 1-12 сар | Эрсдэлийн менежмент, хөрөнгийн удирдлагын газар |
| | | | Хөрөнгө оруулалт болон бусад холбогдох судалгааны ажил хийх, хөрөнгө оруулах боломжит хувилбаруудыг судалгаа, шинжилгээний үндсэн дээр тогтоох | ○ Хөрөнгө оруулалт болон бусад холбогдох судалгааны /судалгаа-2/ ажлыг хийж, хөрөнгө оруулах боломжит хувилбаруудыг зохимжтой байдлаар гаргасан байна. | | |
| | | | Санхүүгийн шинжилгээний үнэлгээ хийх | ○ Санхүүгийн тогтвортой байдлыг ханган ажиллаж байгаа эсэхийг шинжлэн, дүгнэлт хийж, эрт анхааруулах шинжилгээ хийж, тус шинжилгээний үзүүлэлтүүд боломжит түвшиндээ байгаа эсэхийг улирал бүр тогтмол хянаж ажилласан байна. | 1, 4, 7, 10 сар | |
| 16. | 7. | Нөхөн төлбөрийн тооцооллыг үнэн зөв хийж, нөхөн төлбөр олгох үйл ажиллагааг хариуцах; | Нөхөн төлбөрийн тооцооллыг үнэн зөв хийх | ○ Даатгалын тохиолдол бүрд нөхөн төлбөрийн тооцооллыг үнэн зөв хийсэн байна. | | |
| | | | Нөхөн төлбөр олгох асуудлыг хариуцах | ○ Эрсдэлийн хорооны хурлын шийдвэрийг үндэслэн нөхөн төлбөрийг цаг тухай бүрд шийдвэрлэсэн байна. | 1-12 сар | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | o Байгууллагын нэгдсэн систем дээрх нөхөн төлбөрийн тооцооллын бүртгэлийг үнэн зөв бүртгэсэн байна. | 1-12 сар | Эрсдэлийн менежмент, хөрөнгийн удирдлагын газар |
| | | | Улаан буудайн индексжүүлсэн даатгалын давхар даатгалын хураамжийн авлага барагдуулах | o Улаан буудайн индексжүүлсэн даатгалын авлага барагдуулах ажлыг зохион байгуулж, давхар даатгалын хураамжийн орлогыг төвлөрүүлсэн байна. | 1-6 сар | |
| 17. | 8. | Компанийн дотоод үйл ажиллагаа, төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулах; | Компанийн үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд байнгын хяналт тавих | o Дотоод хяналтын ажилтныг холбогдох сургалтуудад хамруулж, үр дүнтэй ажиллуулсан байна.<br>o Дотоод хяналтын үйл ажиллагаа сайжирсан байна. | 1-12 сар | |
| **4. Үйл ажиллагааны хэвийн нөхцөлийг хангах, дотоод ажлын хүрээнд:** | | | | | | |
| 18. | 1. | Компанийн хүний нөөц, хөдөлмөрийн харилцаа, нийгмийн асуудлыг шийдвэрлэх; | Байгууллагын хүний нөөцийн асуудлыг хариуцах, хяналт тавих | o Хүний нөөцийн бодлого, стратеги, төлөвлөгөөг /баримт бичиг-1, төлөвлөгөө-1/ батлуулж, бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.<br>o Ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг оновчтойгоор шинэчилсэн байна.<br>o Сул орон тоон дээрх сонгон шалгаруулалтыг ил тод нээлттэй байдлаар зохион байгуулсан байна. | 1-12 сар | Захиргаа, удирдлагын газар |
| | | | Сургалт хөгжлийн болон олон нийтийн ажлын төлөвлөгөөг боловсруулж батлуулах, хэрэгжилтийг ханган ажиллах | o Сургалт хөгжлийн /төлөвлөгөө-1/ болон олон нийтийн ажлын төлөвлөгөөг /төлөвлөгөө-1/ боловсруулж батлуулан хэрэгжүүлж ажилласан байна. | | |
| | | | Хөдөлмөрийн харилцааны маргаантай асуудлыг шийдвэрлэх, ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй байдалд хяналт тавих | o Хөдөлмөрийн маргаан таслах комисс /тушаал-1/ байгуулагдсан байна<br>o Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн /тушаал-1/ бүрэлдэхүүн шинэчлэгдсэн байна. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | ○ Комисс, зөвлөлийн жилийн ажлын төлөвлөгөөг батлуулж, бүрэн хэрэгжүүлж ажилласан байна. | 1-12 сар | Захиргаа, удирдлагын газар |
| | | | Ажилтнуудын хувийн хэрэг, хөдөлмөрийн гэрээ, бусад бүртгэлийг хөтлөх | ○ Хувийн хэрэг /хавтас-49/ бүрдүүлэлт шинэчлэгдэж, хөдөлмөрийн гэрээ /гэрээ-49/ нь холбогдох дүрэм, журамд нийцэн байгуулагдсан байна.<br>○ Бусад шаардлагатай бүртгэлийн жагсаалт /жагсаалт-1/ гаргаж, бүрдүүлсэн байна.<br>○ Ажилтнуудын мэдээлэл цахимаар бүртгэгдсэн байна. | | |
| 19. | 2. | Компанийн санхүүгийн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилтийг хангах; | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилтийг хангаж ажиллах | ○ Өдөр бүрийн ажил гүйлгээг санхүүгийн программ болох Silicon болон Юникус программд бүртгэсэн байна.<br>○ Ажил гүйлгээ бүрийн баримт бүрдүүлэлт шаардлага хангасан байна. | 1-12 сар | Захиргаа, удирдлагын газар<br>Санхүүгийн алба |
| | | | СТОУС 17 даатгалын гэрээ стандартыг хэрэгжүүлэх | ○ СТОУС 17 стандартаар шаардсан хэмжилт, хүлээн зөвшөөрөлт, толилуулга, тодруулгын шаардлагын дагуу 2023 оны санхүүгийн тайланг бэлтгэсэн байна. | | |
| | | | Компанийн санхүүгийн болон татварын тайланг хариуцан гаргах | ○ Санхүүгийн болон татварын тайланг /санхүүгийн тайлан-4, татварын тайлан-4/ хугацаанд нь гаргасан байна<br>○ Нийгмийн даатгалын тайланг /НД-ын тайлан-12/ хугацаанд нь гаргасан байна.<br>○ Төсвийн гүйцэтгэлийг /гүйцэтгэл-12/ сар бүр гаргаж тайлагнасан байна. | | |
| | | | Компанийн мөнгөн хөрөнгийн бүртгэлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу хөтлөх, тайлагнах | ○ Мөнгөн кассын тайлан /тайлан-12/ хугацаандаа үнэн зөв гарсан байна. | | |
| | | | Компанийн шилэн дансны мэдээллийг хариуцан ажиллах | ○ Шилэн дансны мэдээлэл хугацаандаа үнэн зөв, бүрэн мэдээлэгдсэн байна. | | |
| | | | Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах | ○ Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны тайланг /тайлан-4/ хугацаанд нь гаргасан байна. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | o “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж ажилласан байна. | | |
| | | | Компанийн үндсэн хөрөнгийн хадгалалт хамгаалалт, эмх цэгц, бүрэн бүтэн байдлыг хариуцах | o Үндсэн хөрөнгийн тооллогыг /тооллогын тайлан-2/ холбогдох журамд заасны дагуу чанартай хийсэн байна.<br>o Өмчийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтад тавих хяналт сайжирсан байна | 1-12 сар | Захиргаа, удирдлагын газар Санхүүгийн алба |
| 20. | 3. | Компанийн худалдан авалтын ажиллагааг хариуцан зохион байгуулах; | Компанийн худалдан авалтын үйл ажиллагааг хариуцан ажиллах | o Тендер шалгаруулалтуудыг /тендер-5/ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд сайн зохион байгуулсан байна. | | |
| | | | Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах материалыг бэлтгэх, захиалах, хуваарийн дагуу олгох ажлыг хариуцах | o Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах материал тасалдаагүй, баримт бүрдүүлэлт үнэн зөв, бүрэн бүрдсэн байна.<br>o Компанийн тохижилт, цэвэрлэгээ үйлчилгээ сайжирч, ажиллах таатай орчин нөхцөл бүрдсэн байна.<br>o Машин техникийн үйлчилгээний байнгын бэлэн байдал хангагдсан байна. | | |
| 21. | 4. | Компанийн веб сайт, цахим сурталчилгааг хөгжүүлэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах; | Компанийн веб сайтын агуулга, мэдээллийг шинэчлэх, хөгжүүлэх | o Веб сайтын агуулга, мэдээлэл байнга шинэчлэгдэн хөгжсөн байна. | 1-12 сар | Захиргаа, удирдлагын газар |
| | | | Компанийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй мэдээллийн аюулгүй байдлыг хангах, хяналт тавих | o Мэдээллийн аюулгүй байдлын бодлого, зохицуулалтын асуудлаар холбогдох судалгаа хийж, холбогдох журмыг /журам-1/ боловсруулсан байна.<br>o Компанийн мэдээллийн аюулгүй байдал бүрэн хангагдсан байна. | | |
| 22. | 5. | Компанийн архив, бичиг хэргийн ажлыг хариуцан зохион байгуулах; | Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг дүрэм, журам, заавар, стандартын дагуу хөтлөн явуулах | o Албан хэрэг хөтлөлтийн журмыг /журам-1/ шинэчлэн, түүний дагуу баримт бичиг зохион бүрдүүлж, байгууллагын хэмжээнд мөрдүүлсэн байна. | | |
| | | | Байгууллагын архивын үйл ажиллагааг холбогдох дүрэм, | o Байгууллагын тухайн онд хөтлөгдөх хэргийн нэрийн жагсаалт /ХХНЖ-1/ батлагдсан байна. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | журам, заавар, стандартын дагуу хөтлөн явуулах | o Архивд баримтыг хугацаанд нь жагсаалтаар бүрэн хүлээн авсан байна.<br>o Архивын үйл ажиллагаанд холбогдох дүрэм, журам, заавар, стандартыг мөрдөж ажилласан байна. | 1-12 сар | Захиргаа, удирдлагын газар |
| | | | Байгууллагад иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч хуулийн дагуу шийдвэрлүүлэх | o “Өргөдөл гомдлыг шийдвэрлэх журам” /журам-1/, “Ажилтнуудаас гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам” /журам-1/ шинэчлэн батлагдсан байна.<br>o Ирсэн өргөдөл, гомдол түргэн шуурхай шийдвэрлэгдсэн байна. | | |
| | | | Ажилтнуудад өдөр тутмын ажил үүргээ гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлэх, дотоод ажлыг шуурхай зохион байгуулах | o Газар нэгж, ажилтнуудын хоорондын уялдаа холбоо сайжирч, цаг үеийн ажил түргэн шуурхай зохион байгуулагдаж хэвшсэн байна. | | |
| 23. | 6. | Компанийн хууль эрх зүйн асуудлыг хариуцан зохион байгуулах; | Компанийн үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэх | o Тогтоол, тушаал болон бусад эрх зүйн актын эрх зүйн үндэслэл, найруулга холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.<br>o Шаардлагатай дүрэм, журам батлагдаж хэрэгжсэнээр компанийн өдөр тутмын үйл ажиллагаа хэвийн, тасралтгүй явагдах нөхцөл бүрдсэн байна.<br>o Гэрээ, албан бичгийн эрх зүйн үндэслэл, найруулга холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.<br>o Компанийн үйл ажиллагаатай холбогдох хэрэг, маргаанд компанийн эрх ашгийг хуулийн байгууллагад төлөөлж, компанийн эрх ашгийг холбогдох хууль, эрх зүйн хүрээнд хамгаалж ажилласан байна. | | |

------------------- o O o ------------------